



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.07.31 № 255

танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Говь-Алтай аймгийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

0702 00715

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн Ардчилсан намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


Говь-Алтай аймгийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Говь-Алтай аймгийн Ардчилсан намд

Хувийг: Говь-Алтай аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Говь-Алтай аймгийн Ардчилсан намын хорооны
2024 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн
09 дугаар тогтоолын хавсралт



80+ ИРГЭНЭЭ ДЭЭДЭЛСЭН ХӨГЖЛИЙН ЦОГЦ ШИЙДЭЛ

2024-2028 он

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН
2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Алтай хот
2024 он



АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Эрүүл мэнд
- 1.2. Боловсрол
- 1.3. Соёл, урлаг
- 1.4. Биеийн тамир, спорт
- 1.5. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж
- 1.6. Гэр бүл, хүүхэд, залуучууд

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. Төсөв, санхүү
- 2.2. Уул уурхай
- 2.3. Аялал жуулчлал
- 2.4. Хөдөө аж ахуй

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1. Төрийн үйлчилгээ
- 3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- 3.3. Батлан хамгаалах
- 3.4. Гадаад хамтын ажиллагаа

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1. Байгаль орчин

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1. Эрчим хүч
- 5.2. Зам тээвэр
- 5.3. Газрын харилцаа, барилга, хот байгуулалт



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. ЭРҮҮЛ МЭНД

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадлыг хэвшүүлнэ.

1.1.1. “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

1.1.2. Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.3. Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй болон сэргийлж болох өвчлөл, нас баралтыг бууруулж, урьдчилан сэргийлнэ.

1.1.4. Чанаргүй хүнсний бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог сайжруулан, хүн амын транс тос, сахар, давсны болон архи, тамхины хэрэглээг бууруулах арга хэмжээ авна.

1.1.5. Гэмтэл, ослыг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулан, энэ төрлийн нас баралтын хувийг бууруулна.

1.1.6. Нас баралтыг бууруулах зорилгоор жендэрт суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үйл ажиллагааг өргөжүүлэн, эрчүүдийн нас баралтыг бууруулна.

1.1.7. Өрхийн болон сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинэчилэх, сэргээн засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.1.8. Багийн эмч нарыг унаажуулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.

1.1.9. Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.10. Баруун бүсийн уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2. БОЛОВСРОЛ

Дэлхийн боловсролыг орон нутагт нь эзэмшүүлнэ.

1.2.1. “Боловсролын чанарыг сайжруулах” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, сургалтын чанарын үзүүлэлтийг жил бүр нэмэгдүүлнэ.



1.2.2. Боловсролын салбарын багш, үйлчилгээний албан хаагчдын ажлыг бодитойгоор үнэлж, урамшуулах тогтолцоог хэрэгжүүлнэ.

1.2.3. Боловсролын салбарын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.4. Англи хэлний боловсролыг бодлогоор дэмжиж, гүнзгийрүүлсэн сургалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

1.2.5. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны барилгыг шинээр барих, их засварт оруулах, дэд бүтцийг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, орчин нөхцөлийг сайжруулна.

1.2.6. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, сурч хөгжих орчин нөхцөлийг сайжруулна.

1.2.7. Хичээлээс гадуурх сургалт, дугуйлангийн тоо, хамрагдалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг өргөтгөнө.

1.2.8. Мэргэжилтэй боловсон хүчин сургаж бэлтгэхэд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

1.2.9. Баруун бүсийн эрүүл мэндийн салбарын боловсон хүчинг сургаж бэлтгэхэд АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаахын салбар сургуулийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

1.3. СОЁЛ, УРЛАГ

Соёл, урлагийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлж, мартагдсан өв, соёлыг сэргээн, орчин үеийн чиг хандлагатай хослуулан хөгжүүлнэ.

1.3.1. Чөлөөт өрсөлдөөний зарчимд нийцүүлэн, соёл, урлагийн байгууллагуудын нэмэлт орлого олох боломж, нөхцөлийг нэмэгдүүлнэ.

1.3.2. Монгол түмний хүсэл мөрөөдлийг илэрхийлсэн хүчтэй, эвтэй, элбэг хангалуун байхын бэлгэдэл “Туульсын хаан Жангар” арга хэмжээг тогтмол зохион байгуулж, нутгийн ондоошлыг илэрхийлсэн эвент арга хэмжээ болгоно.

1.3.3. Биет бус соёлын өвийг бүртгэж, хадгалах зорилгоор дүрс бичлэг бүхий дижитал архив үүсгэнэ.



1.3.4. Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг олон улсын зах зээлд гарахад бодлогоор дэмжинэ.

1.3.5. Байгаль, түүхийн дурсгалт газрууд, соёлын бүтээгдэхүүний виртуал бодит аяллыг хөгжүүлнэ.

1.3.6. Сумдын соёлын төвийн барилгыг шинээр барих, их засварт оруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.3.7. Соёлын мэргэжлийн боловсон хүчний ур чадварыг бодитойгоор үнэлж, урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

1.3.8. Соёлын салбарын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.9. Өрхийн угийн бичиг хөтлөлтийг 70.0 хувьд хүргэнэ.

1.3.10. Иргэдийн үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

1.4. БИЕИЙН ТАМИР, СПОРТ

“Говь-Алтай 80+” хөтөлбөрийн хүрээнд нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг болгоно.

1.4.1. Тамирчдын бүс, улс, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

1.4.2. Өсвөрийн шигшээ багуудыг дэмжин ажиллаж, тамирчдын ур чадвар, амжилтыг ахиулна.

1.4.3. Идэвхтэй дасгал, хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.

1.4.4. Сумдын спорт заал, биеийн тамирын талбайн барилгыг шинэчлэх, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

1.5.1. Ажилгүйдлийн түвшинг 5.0 хувиас бага түвшинд байлгах хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.



1.5.2. Ажлын байр шинээр бий болгох хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ.

1.5.3. “Инноваци бизнес төв”-ийг байгуулж, тав тухтай орчинд бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэн, бизнесийг нь өргөжүүлнэ.

1.5.4. Инновацид суурилсан гарааны бизнесийг дэмжинэ.

1.5.5. Бага орлоготой өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулж, ажлын байранд зуучилна.

1.5.6. “Ахмадын холбоо, сувиллын барилга”-ыг ашиглалтад оруулж, ахмад настны хөгжил оролцоог дэмжинэ.

1.5.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг бусдын адил бизнес эрхлэх, сурах, хөдөлмөрлөх боломжоор хангаж, тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

1.5.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах төвийг байгуулна.

1.5.9. Төрийн байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно.

1.6. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжил оролцоог дэмжинэ.

1.6.1. Гэр бүлгүй залуучуудын “Жангар” олон улсын эвент арга хэмжээг жил бүр зохион байгуулна.

1.6.2. “Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг ашиглалтад оруулж, үйлчилгээний чанарыг сайжруулна.

1.6.3. “Засагт ханы хот айл” гэр зусланг сум бүрт байгуулах ажлыг үргэлжлүүлж, хүүхэд багачуудыг Монгол ахуй, өв соёл, зан заншил, амьдрах ухаанд суралцуулна.

1.6.4. “Засагт ханы залуус” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.6.5. Малчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор “Залуу малчин гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.



1.6.6. Соёл амралтын “Мазаалай” цэцэрлэгт хүрээлэнг иж бүрэн тохижуулж, ашиглалтад оруулан, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх орчинг бүрдүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. ТӨСӨВ, САНХҮҮ

Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангаж ажиллана.

2.1.1. Орон нутгийн төсвийн 80 хүртэл хувийг өөрийн орлогоор бүрдүүлнэ.

2.1.2. Малын тоо толгойн албан татвар болон орон нутагт тогтоодог албан татвар, төлбөр, хураамжийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх бодлого баримтална.

2.2. УУЛ УУРХАЙ

Ашигт малтмал олборлох, боловсруулах, үйлдвэрлэлд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй, дэвшилтэт техник, хаягдалгүй технологийг дэмжих, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.

2.2.1. Хайгуул судалгааны ажлын үр дүнг дээшлүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг түшиглэн ашигт малтмалын нөөцийг тогтооно.

2.2.2. Ашигт малтмалын орд газрыг ашиглахдаа бүс нутаг, сумдын хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж, ажилгүйдлийг бууруулах, нийт ажиллагсдын 40-өөс доошгүй хувийг сум, орон нутгаас авч ажиллуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.3. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлтийг 108 сая мод ургуулах арга хэмжээтэй уялдуулан зохион байгуулна.

2.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Аялал жуулчлалын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

2.3.1. “Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.3.2. Амралт, сувиллын газар, жуулчны баазуудын хүчин чадлыг хувийн хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлнэ.

2.3.3. Аялал жуулчлалын салбарын ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлнэ.

2.3.4. Аялал жуулчлалын бүсүүдэд отоглох цэгийг нэмж байгуулна.



2.3.5. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлж, эвент арга хэмжээний тоог нэмэгдүүлнэ.

2.3.6. Аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлнэ.

2.3.7. Спорт, эрүүл мэнд, явган алхалт, эко туризм зэрэг нүүдэлчний өв соёлыг сурталчилах аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг бодлогоор дэмжинэ.

2.4. ХӨДӨӨ, АЖ АХУЙ

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

2.4.1. “Малын эзэн - үйлдвэрийн эзэн” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, мах, сүү, арьс шир, ноос ноолуур боловсруулах дундаас дээш хүчин чадалтай үйлдвэрийг байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.4.2. Мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдасгах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.3. Өндөр ашиг шимтэй үндэсний болон дасан зохицох чадвартай гадаадын үржлийн малыг өсгөн бойжуулах үржлийн аж ахуйг хөгжүүлж, малчдад чанартай, таваарлаг малтай болох боломжийг бүрдүүлнэ.

2.4.4. Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “Малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

2.4.5. Мах, сүү, тахианы эрчимжсэн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.

2.4.6. “Газар тариалан, жимс жимсгэнэ” төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.4.7. Усалгаатай газар тариаланг хөгжүүлэхэд услалтын систем шинээр байгуулах, сэргээн засварлах ажлуудын санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ.

2.4.8. Малын тэжээлийн үйлдвэрлэлийн бизнес эрхлэхэд чиглэсэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэн, орон нутгийн дотоодын хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.



2.4.9. Хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, ШИНЭ НОГООНЫ НЭР төрөл, хангамжийг сайжруулна.

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, сахилга хариуцлагыг сайжруулна.

3.1.1. Төрийн үйлчилгээг очиж биш, байгаа газраасаа авах, төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөл бүрдүүлж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

3.1.2. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны шинэ дэвшилтэт технологиуд, инновацийг нэвтрүүлж, “Цахим Алтай хөтөлбөр”-ийг эрчимжүүлнэ.

3.1.3. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийгмийн баталгааг сайжруулна.

3.1.4. Бүх шатны төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж, жил бүр сургалтад хамруулна.

3.1.5. Аймаг, сумдад иргэдэд үйлчлэх “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг барьж байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

3.2.1. Иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх камержуулалтын ажлыг үргэлжлүүлж, үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

3.2.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумдад ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийг аймгийн теле хяналтын нэгдсэн системд холбоно.

3.3. БАТЛАН ХАМГААЛАХ

3.3.1. Зэвсэгт хүчний анги нэгтгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, орон нутгийн бүтээн байгуулалтад хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ.

3.3.2. Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн ажилчдын 50 айлын орон сууцны барилга барьж ашиглалтад оруулна.



3.4. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

3.4.1. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, хөрш орны хил залгаа хот мужуудтай уламжлалт харилцаагаа өргөжүүлж, эдийн засаг, бизнес, нийгэм, соёл, аялал жуулчлалын харилцааг шинэ шатанд гаргана.

3.4.2. НҮБ болон олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулж, орон нутагт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1. БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчныг хамгаалан, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулна.

4.1.1. “108 сая мод” тарьж ургуулах арга хэмжээний хүрээнд уст цэгийг түшиглэн ойжуулалт, хамгаалалтын ойн зурвас, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.1.2. Гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор булаг шандны эхийг хашиж хамгаална.

4.1.3. Хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах, гол, булаг шандны урсацын тохируулга хийх замаар хөв цөөрөм, усан сан байгуулна.

4.1.4. Цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилгоор хамгаалалтын ойн зурвас байгуулж, заган ойн байгалийн сэргэн ургалтыг дэмжих, говь хээрийн унаган ургамлыг тарималжуулах ажлыг зохион байгуулна.

4.1.5. Ус, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1.6. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, боловсруулах цогц менежментийг хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. ЭРЧИМ ХҮЧ

Дулаан, цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.



5.1.1. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэн дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, бүс нутгийн хэмжээнд нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

5.1.2. Аймгийн төвд 29 мВт-ын хүчин чадалтай дулааны станцыг ашиглалтад оруулан, инженерийн шугам сүлжээг бүрэн шинэчилнэ.

5.1.3. Говь-Алтай аймгийн төв Есөнбулаг сумын 6/0.4 кВ-ын дэд станцуудыг 10/0.4 кВ-ын дэд станцууд болгон шинэчилнэ.

5.2. ЗАМ ТЭЭВЭР

5.2.1. Аймгийн төвийн хатуу хучилттай авто замыг 26.5 км-ээр нэмэгдүүлнэ.

5.2.2. “Зорчигч тээврийн авто үйлчилгээний төв”-ийн барилгыг ашиглалтад оруулна.

5.2.3. Төв суурин газрын авто зам, дугуйн зам, явган замын ажлыг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.

5.3. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА

5.3.1. “Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил” төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, сумандаа хэрэглээний халуун устай, дэд бүтцэд бүрэн холбогдсон орон сууцанд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.3.2. Сумдад 50 м³/хоног бүхий цэвэрлэх байгууламжийг барьж, ашиглалтад оруулна.

5.3.3. Алтай хотын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.

5.3.4. Төр, хувийн хэвшилтэй хамтран ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөлтөд оруулах ажлыг зохион байгуулна.

5.3.5. Алтай хотод амины орон сууцны “Солонго хаус” хорооллыг шинээр байгуулж, ашиглалтад оруулна.

5.3.6. Аймгийн төв цэвэрлэх байгууламжийг 3000 м³/хоног болгон өргөтгөж, ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн шинэчилнэ.



5.3.7. Аймгийн төвийг үерийн эрсдэлээс хамгаалах далан байгуулна.

5.3.8. Алтай хотын төвийн гудамжуудыг иж бүрэн тохижуулна.

5.3.9. Гэр хорооллын дэд бүтцийг зохих түвшинд шийдэж, айл бүрийг хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.3.10. Сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулна.

5.3.11. Хиймэл оюун ухаан болон блокчэйн технологид суурилсан газрын үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг бий болгоно.

5.3.12. Газрын кадастрын нэгдсэн ухаалаг систем байгуулж, иргэн төвтэй төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

5.3.13. Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.

---oOo---